



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017.03.15 № 02-01-001/50
танай _____ -ны № _____ -т

Г Мэдэгдэл хүргүүлэх тухай Г

Үйлдвэрлэлийн явцад ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангаагүйгээс ажилтнууд үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан болон ердийн өвчлөлд өртөх, химийн бодисын хурц ба архаг хордлогод орж хөдөлмөрийн чадвараа бүр буюу түр хугацаагаар алдах явдал өсөн нэмэгдэх хандлагатай байна. Иймд үйлдвэрлэл эрхэлж буй ажил олгогч, хөдөлмөр эрхэлж буй ажилтан нар ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, ажилчдын эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал тавьж, аливаа өвчлөл, хордлогоос урьдчилан сэргийлэн ажиллахыг мэдэгдье. Үүнд:

1. Монгол Улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, холбогдох дүрэм, журам, ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөж, ажилтны эрүүл мэндийг сахин хамгаалах асуудалд онцгой анхаарах;

2. Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тоот “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” тушаалын дагуу 50-100 хүртэл ажилтантай тохиолдолд нэг ба түүнээс дээш орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай, 100-аас дээш ажилтантай тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэцтэй байна, ажлын байрны эрсдлийн түвшин ихтэй уул уурхай, эрчим хүч, зам барилгын салбар болон үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлс бүхий аж ахуйн нэгж, байгууллагад ажилтны тооноос хамаарахгүйгээр нэг ба түүнээс дээш орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан ажиллуулна” заалтыг мөрдөж ажиллах;

3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чанар, үр нөлөөг сайжруулах зорилгоор том аж ахуйн нэгжүүд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт хийх орчин үеийн багаж, тоног төхөөрөмжтэй болох, жижиг аж ахуйн нэгж мэргэжлийн байгууллагаар хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах;

4. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын дагуу ажлын байран дахь сөрөг хүчин зүйлс /тоосжилт, химийн бодисын ууршилт, дуу шуугиан, доргион, халуун хүйтэн, уур, чийг, цахилгаан соронзон орон, хэт ягаан туяа г.м/-тэй тэмцэхэд чиглэсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавьж, эрүүл ахуйн норм стандартын хэмжээнд байлгах;

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу ажилтан бүрт ажлын онцлогт тохирсон ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг зөв сонгон хэрэглэх, хангалтыг сайжруулах, ашиглалтын байдалд тогтмол хяналт тавих;

Мэдэгдэл хүргүүлсэн аж ахуйн нэгжийн жагсаалт

1. Суурь ХХК
2. Дэвжих-Эрдэнэ ХХК
3. Арияа ХХК
4. Монгол дээвэр ХХК
5. Арц суварга ХХК
6. Ялгуусан ХХК
7. Төгс зам ХХК
8. Фучер холдинг ХХК
9. Финпак ХХК
10. Монгол итали кашемир ХХК
11. Буурал гол ХХК
12. Гофромануфакторинг ХХК
13. Хау юу жиан цайе ХХК
14. Арилдий ХХК
15. Хээр адуу ХХК
16. Дашваанжил ХХК
17. Энагүрэ ХХК
18. Пу Фа ХХК
19. Лианчин ХХК
20. Насны зам ХХК
21. Наранбулаг ХХК
22. Ви Си ХХК
23. Ньюпэйс ХХК
24. Газар сүлжмэл ХХК
25. Янмал ХХК
26. Улаанбаатар БҮК ХХК
27. Хурд төмөр бетон ХХК
28. Амгалан дулааны станц
29. Эверэст сайхан ХХК
30. ЭДКС ХХК
31. Дархан минж
32. Фрэндшипсансам трейдинг ХХК
33. Нарта ХХК
34. Хүрд трейд ХХК
35. М Си ЭсАзия Пасифик тайгер үйлдвэр
36. MCS кока кола
37. Витсамо фрүтжүүс
38. Очир дагинас
39. Хүнскомплекс
40. Мөнхжин Од
41. Тохижилт үйлчилгээний газар 1
42. Хот тохижилт БХЗХ
43. УБ зам арчлалт
44. УБЦТС Зүүн түгээх төв
45. Лакс ХХК
46. ХАОЕН ХХК
47. Топ шилэн хийц ХХК
48. Цонх констракшн ХХК
49. Хэв хашмал хуванцар ХХК
50. "Бэст дрийм" ХХК
51. Нопсан ХХК
52. Полипак

53. Шинэ тоосго ХХК
54. Мах импекс ХХК
55. Сүү ХК
56. Монгол керамик ХХК
57. Тэжо ХХК
58. Наран гол тоосго ХХК
59. Хос гол ХХК
60. Резинэн эдлэл ХХК
61. Батгүен ХХК
62. Боорчи ХХК
63. Зөв зуурмаг ХХК
64. Би Ди Ай Би ХХК
65. Капиталфактори ХХК
66. Сүүтэй хайрхан ХХК
67. Юнико ХХК
68. Мянга эсгий ХХК
69. Түмэн эсгий туургатан ХХК
70. Шилэн хийц ХХК
71. Инэл кашемир ХХК
72. Фючер оф пластик ХХК
73. Эм Жи Эл цемент ХХК
74. Увт Инвест ХХК ХХК
75. Төгс зуурмаг ХХК
76. Алтан Аураг констракшн ХХК
77. Минжийн хангайн төгөл ХХК
78. Мандахбулаг ХХК
79. Эсто ХХК
80. Ерөөлт интернешнл ХХК
81. Хатантөгөл ХХК
82. Тотал-Инж ХХК
83. Хунжүй ХХК
84. Блюскай кашемир ХХК
85. Ариг гал ХХК
86. Эм Ди Си Пи ХХК
87. Шунхлайпетролиум ХХК
88. Экопак ХХК
89. ОБ пластик ХХК
90. Алко групп ХХК
91. Далай буян ХХК
92. Эс Ди сервис ХХК
93. Смарт крафт ХХК
94. Тэдмэнтбетон зуурмаг ХХК
95. Хөнгөн тавцан ХХК
96. Улаанбаатар буйдан хийц ХХК
97. Таванбогд менежмент ХХК
98. Цэнгэлдэх ОСНААК ХХК
99. Хан-Уул тохижилтын үйлчилгээ ХХК
100. Бяцхан дельфин ХХК

6. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтын дагуу ажилтны эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгийг тогтоосон хугацаанд чанартай явуулан, мэргэжлээс шалтгаалах болон ердийн өвчлөлийг эрт илрүүлэн оношлох, эмчлэн эрүүлжүүлэх;

7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалтын дагуу ажилтны ахуй хангамжийн байр /хувцас солих, амрах, хооллох, усанд орох, гар угаах, бие засах газар /-ыг эрүүл ахуй шаардлагад нийцүүлэн тав тухтай орчинг бий болгож тогтмол ариутгал халдваргүйтгэл хийх, ажлын байранд ундны цэвэр ус, түр амрах байр хангах, гэмтэл, бэртэл тохиолдох үед үзүүлэх анхан шатны тусламжийн бэлэн байдлыг хангуулах;

8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалтын дагуу ажилтныг илчлэг, чанар сайтай, амин дэмээр баялаг хоол хүнсээр хангах замаар ажилтны эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд дэмжиж ажиллах;

9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.8 дахь заалтын дагуу инженер техникийн ажилтан, үйлдвэрийн ажилтнуудад эрүүл мэндийн боловсрол олгох, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;


10. Үйлдвэрийн цех тасаг, нэгжүүдийн дунд Эрүүл ажлын байр-Эрүүл хамт олон, эрүүл дадал заншил, зан үйлийг бий болгох зэрэг бүтээлч аян, хөдөлгөөн өрнүүлж, үр дүнгээр урамшуулал олгох журам бий болгох

11. Засгийн газрын 311 дүгээр тогтоолын баталсан байгууллагын дотоод хяналтын журмын дагуу дотоод хяналтын нэгж, ажилтан томилох, өөрийн үйл ажиллагаандаа тохирсон дотоод хяналтын журам боловсруулан, хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцдог байх;

Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.2, 36.4 дэх заалтуудыг үндэслэн хуулийн хариуцлага хүлээдэг болохыг мэдэгдье.

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА, УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Л. ЭРДЭНЭЧУЛУУН

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА, УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  С.ДАВААСҮРЭН

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ТУСГАН
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА, ХӨДӨЛМӨРИЙН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  И.БАТТӨГС

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ 

Ч.БҮЖИНЛХАМ